



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

┌ Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 63.1.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 55.1.2-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 08 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам” /цаашид “журам” гэх/-д дор дурдсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай:

1/ Журмын 2.2.5-д “Менежментийн компани нь 3-аас доошгүй гишүүнтэй ТУЗ-тэй байх бөгөөд тэдгээрийн олонхи нь хараат бус гишүүн байна...” гэснийг “Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь 3-аас доошгүй гишүүнтэй ТУЗ-тэй байх бөгөөд тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна ...” гэж өөрчлөх;

2/ Журмын 2.2.6.3-д “... зэрэгтэй гэснээс хойшхи төслийн үнэлгээ” хүртэлх хэсгийг хасах;

3/ Журмын 2.2.6.3.5 дах хэсгийг 2.2.6.5 дах заалт болгон өөрчлөх;

4/ Журмын 2.2.7-д “...эрх авсан гэсний дараах “энэ чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан” гэснийг хасах;

5/ Журмын 3.1.8-д “... хангаж байгаа тухай гэсний дараа “тэдгээр этгээдийн өөрийн гараар бичиж нотариатаар баталгаажуулсан тодорхойлолт, холбогдох диплом сертификатын хуулбар” гэснийг хасаж, “нотлох баримтууд” гэж өөрчлөх.

2. Журамд холбогдох өөрчлөлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, Бүртгэл зөвшөөрлийн газар /Ю.Нэргүй/-т тус тус даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭГЭГЧ
ДЭД ДАРГА  Э.БАТБОЛД

